



**ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/158

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.3, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Таван толгой түлш" ХХК-ийн "Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам"-ыг хавсралтаар баталсугай.

2."Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам" шинэчлэн батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2021 оны А/158 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нийт ажилтан, албан хаагчдад танилцуулан ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Э.Ууганцэцэг)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ЛХАГВАСҮРЭН

“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН
БҮРДҮҮЛЭЛТ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.“Таван толгой түлш” ХХК-ийн хүний нөөц бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтыг шударга, ил тод, нээлттэй зохион байгуулах, албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, мэдлэг, ур чадвар, тавигдах шаардлагыг хангасан иргэнийг сул ажлын байранд сонгон шалгаруулах харилцааг зохицуулахад энэ журмыг баримтална.

1.2.Ажилтан сонгон шалгаруулахад Монгол улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад хууль, тогтоомжийг баримтална.

Хоёр. Ажилтан сонгон шалгаруулах ажлын үе шат

2.1.Ажлын байрны сонгон шалгаруулалтыг олон нийтэд мэдээлэх.

2.2.Бичиг баримтыг үнэлэх.

2.3 Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах.

2.4.Үр дүнг үнэлэх, мэдээлэх.

Гурав.Сонгон шалгаруулалтыг мэдээлэх

3.1.Сул ажлын байрны зарыг байгууллагын цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

3.2.Компанийн сул орон тоог ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжил, мэдлэг, туршлагын болзол хангасан ажиллаж байгаа үндсэн албан хаагчдаас нөхөх, шилжүүлэн томилох, хавсран гүйцэтгүүлэх боломжтой бол олон нийтэд зарлахгүй.

3.2.Мэдээлэлд тухайн ажлын байранд тавигдах шаардлага, албан тушаалын нэр, ажлын байрны байршил, бүрдүүлэх материал, харилцах утасны дугаар, материал хүлээн авах, бүртгэх, сонгон шалгаруулалт явуулах байр, хугацаа зэргийг заана.

3.3.Хүний нөөц хариуцсан нэгж нь батлагдсан ажлын байрны зарыг зарлуулах ажлыг хариуцна.

Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцогчдын материал хүлээн авах

4.1.Компаниас зарлагдсан ажлын байранд материалыг зар олон нийтэд хүргэсэн өдрөөс хойш ажлын 3-аас доошгүй хоногийн хугацаанд хүлээн авна.

4.2.Энэ журмын 4.1 дэх хэсэгт заасан хугацаа хэтрүүлсэн материалыг хүлээн авахгүй.

4.3.Сонгон шалгаруулалтад оролцох иргэд дараах материал бүрдүүлэн ирүүлнэ.

4.3.1.Анкет (зураг-1 хувь);

4.3.2.Боловсрол, мэргэжлийн үнэмлэх, дипломын, мэргэшлийн эрхийн үнэмлэх хуулбар;

4.3.3.Иргэний үнэмлэхийн хуулбар;

4.3.4.Нийгмийн даатгалын лавлагаа;

4.3.5.Оршин суугаа газрын лавлагаа;

4.3.6.Цагдаагийн газрын тодорхойлолт.

4.4.Зарлагдсан ажлын байрыг сонирхсон иргэн компанийн цахим хуудсаар энэ журмын 4.3-д заасан материалыг өгч болох бөгөөд сонгон шалгаруулалтад оролцохдоо материалыг эх хувиар ирүүлнэ.

4.5.Шалгаруулалтад оролцогч иргэн энэ журмын 4.3 дахь хэсэгт заасан материал бүрэн ирүүлээгүй нөхцөлд сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.

Тав. Сонгон шалгаруулалт

5.1.Дотоод сонгон шалгаруулалт.

5.1.1.Компанийн сул орон тоог ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжил, мэдлэг, туршлагын болзол хангасан "Таван толгой түлш" ХХК-ийн ажилтнуудад нээлттэй байдлаар сонгон шалгаруулалт явуулж болно.

5.1.2.Компанийн удирдах албан тушаалд байрны тодорхойлолтод заасан мэргэжил, мэдлэгийн шалгуур хангасан ажилласан туршлагын 50-аас дээш хувийн болзол хангасан үндсэн ажилтныг шатлан дэвших зарчмаар албан тушаал дэвшүүлэн томилж болно.

5.2.Ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт.

5.2.1.Ажлын байрыг нээлттэй сонгон шалгаруулалт явуулахад Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журам, энэ журам болон бусад эрх зүйн актуудыг баримтална.

5.2.2.Сонгон шалгаруулалтыг шударга, нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлан сул орон тооны ажлын байрыг энэ журмын 3 дугаар зүйлд заасны дагуу нийтэд нээлттэй зарлана.

5.2.3.Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж нь энэхүү журмын дагуу ажлын байрны сул орон тоог нээлттэй зарлан сонгон шалгаруулах ба энэ журмын 6.4 дэх хэсэгт заасан хүний нөөцөд бүртгэгдсэн иргэдээс болзол тавигдах шаардлага хангасан иргэдээс сонголт хийн ажилд томилж болно.

Зургаа.Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

6.1.Сонгон шалгаруулалтыг Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжээс зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулан сонгон шалгаруулалт явуулж болно.

6.2. Сонгон шалгаруулалтыг Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжээс дараах үе шатаар зохион байгуулна.

6.2.1. Сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалыг энэ журмын 4.3 дахь хэсэгт заасан бүрдэл хангаж байгаа эсэх, ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшил, ажлын туршлагыг хангаж байгаа эсэхийг үнэлнэ.

6.2.2. Энэ журмын 6.2.1 дэх заалтад заасан шалгуурыг хангасан иргэдээс дараах чиглэлээр сонгон шалгаруулалтыг зохион байгуулж нийт 100 оноогоор үнэлнэ.

6.2.2.1. Ерөнхий мэдлэгийн шалгалтын сорил 20 оноо.

6.2.2.2. Ажлын байранд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журмын сорил 50 оноо.

6.2.2.3. Ажлын ярилцлага 30 оноогоор үнэлнэ.

6.2.3.4. Үйлдвэрийн дээд боловсрол шаардахаас бусад нарийн мэргэжил шаардах ажилтанд ярилцлага хийхгүй ур чадварын 30 хүртэл оноогоор үйлдвэрийн Инженер техникийн ажилтнууд үнэлнэ.

6.2.3. Энэ журмын 6 дугаар зүйлийн 6.2.2.1, 6.2.2.2 дахь дэд заалтад заасан шалгалтын нийт босно оноо 40 байна. Босго онооны болзол хангаагүй иргэнийг ярилцлага оролцуулахгүй.

6.2.4. Энэ журмын 6 дугаар зүйлийн 6.2.2.3 дахь дэд заалтад заасан ярилцлагын доод оноо 9 байна.

6.2.5. Шалгалтыг дараах чиглэлээр авна.

№	Шалгалтын чиглэл	Хамрагдах ажлын байр	Хамаарах асуудлууд
1	Ерөнхий мэдлэгийн шалгалтын сорил	Удирдах албан тушаал	- Асуудал шийдвэрлэх чадвар - Дүн шинжилгээ хийх чадвар - Монгол хэл - Мэдээллийн технологи - Бусад
		Гүйцэтгэх албан тушаал	- Дүн шинжилгээ хийх чадвар - Монгол хэл - Мэдээллийн технологи - Бусад
		Үйлдвэрийн ажилтан	- Монгол хэл - Бусад
2	Ажлын байранд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журмын сорил	Удирдах албан тушаал	- Үндсэн хууль - Хөдөлмөрийн тухай хууль - Компанийн тухай хууль - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль - Бусад
		Гүйцэтгэх албан тушаал	- Үндсэн хууль - Хөдөлмөрийн тухай хууль - Компанийн тухай хууль - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль - Бусад
		Үйлдвэрийн ажилтан	- Үндсэн хууль - Хөдөлмөрийн тухай хууль - Бусад

3	Ажлын ярилцлага	Удирдах албан тушаал	- Удирдан зохион байгуулах - Манлайлах чадвар - Багаар ажиллах чадвар - бусад
		Гүйцэтгэх албан тушаал (оффисын болон үйлдвэрийн нарийн мэргэжил шаардахгүй ажилтан)	- Өөрийгөө илэрхийлэх чадвар - Багаар ажиллах чадвар - Компани, ажлын байр сонгосон шалтгаан, нөхцөл
4	Ур чадварын шалгалт	Үйлдвэрийн нарийн мэргэжлийн ажилтан	- Тухайн мэргэжлийн ур чадвар

6.3. Ажилд орохыг хүссэн иргэд энэ журмын 6.2.2 дахь заалтад заасны дагуу сонгон шалгаруулалтад орох бөгөөд 60 болон түүнээс дээш оноо авсан иргэнийг ажлын байрны тавигдах шаардлага хангасан гэж үзнэ.

6.3. Энэхүү журмын 6.3 дахь заалтын дагуу шалгаруулалтад орж хамгийн өндөр оноо авч тэнцсэн иргэнийг гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулан ажилд томилно.

6.4. Тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан энэ журмын 6.3 дахь заасан болзол шалгуурыг хангасан ч хамгийн өндөр оноо авч чадаагүй, томилогдоогүй иргэнийг өөрийн хүсэлтээр 6 сарын хугацаанд нөөцөд бүртгэнэ.

6.6. Сонгон шалгаруулалтад сонгогдсон иргэн өөрийн хүсэлтээр тухайн ажилд томилогдохоос татгалзсан тохиолдолд дараагийн шаардлага хангасан сонгон шалгаруулалтад оролцсон иргэнийг томилж болно.

Долоо. Бусад

7.1. Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжээс энэхүү журмыг хэрэгжүүлэхэд аливаа албан тушаалтан хөндлөнгөөс оролцох нөлөөлөхийг хориглоно.

7.2. Ажилд орохыг хүссэн иргэний анкет, ажилтны хувийн хэрэг, шалгалтын материалыг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, үзүүлэхийг хориглоно.

7.3. Ажлын байрны тодорхойлолт нь тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжил, мэргэшил, ур чадвар, хандлага, туршлага багтаасан тул сонгон шалгаруулалт явуулахад баримтлах үндсэн шалгуур болно.

7.4. Сул ажлын байранд шинээр ажилтан, албан хаагч сонгон шалгаруулах үйл явцыг уг албан тушаал дээр одоо байгаа ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа (албан тушаал дэвшүүлэх, өөр албан тушаалд томилох, чөлөөлөгдөх, хөдөлмөрийн гэрээ цуцлах, дуусгавар болох зэргийг) эцэслэн дууссаны дараа эхлүүлнэ.

**СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Мая

Сонгон шалгаруулалтад оролцогчийн материалын шалгалтын хуудас бүрдлийн хуудас

№	Сонгон шалгаруулалтад оролцогчийн овог нэр	Материал ирүүлсэн албан тушаал	Анкет (зургаан хувь)	Боловсрол, мэргэжлийн үнэмлэх, дипломын, мэргэшлийн эрхийн үнэмлэх хуулбар	Иргэний үнэмлэхний хуулбар	Нийгмийн даатгалын лавлагаа	Оршин суугаа газрын лавлагаа	Цагдаагийн газрын тодорхойлолт	Материал бүрэн эсэх /тийм үгүй/	Ажлын байдлыг тодорхойлсд нийцэж байгаа эсэх
1										
2										
3										
4										
5										
6										

Хүний нөөцийн ажилтан /ажлын хэсэг

..... /

Огноо.....

**СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Сонгон шалгаруулатад хамрагдсан иргэн.

_____ /Эцэг, эхийн нэр/
 _____ /Өөрийн нэр/
 _____ /Регистрийн дугаар/

Ажиллахыг сонирхож буй

Алба, хэлтэс _____

Албан тушаал _____

№	Үнэлгээ өгөх нэгж	Ерөнхий мэдлэгийн сорил /20 оноо	Ажлын байрнд мөрдөгддөг хууль тогтоомж, дүрэм, жуамын сорил / оноо 50/	Ажлын ярилцлага / оноо 30/	Нийт
1	Хүний нөөцийн мэргэжилтэн /ажлын хэсэг/	-	-	-	-
Нийт оноо					-

Ажлын ярилцлага: Удирдах ажилтан

№	Хүний нөөцийн ярилцлага	Удирдан зохион байгуулах /3-10 оноо/	Манлайлах чадвар /3-10 оноо/	Багаар ажиллах чадвар /3-10 оноо/	Нийт /9-30 оноо/
1	Хүний нөөцийн ажилтан /ажлын хэсэг/				

ҮНЭЛГЭЭ НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН /АЖЛЫН ХЭСЭГ/

...../...../

ОГНОО.....

**СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Сонгон шалгаруулатад хамрагдсан иргэн.

_____ /Эцэг, эхийн нэр/
 _____ /Өөрийн нэр/
 _____ /Регистрийн дугаар/

Ажиллахыг сонирхож буй

Алба, хэлтэс _____

Албан тушаал _____

№	Үнэлгээ өгөх нэгж	Ерөнхий мэдлэгийн сорил /20 оноо	Ажлын байрнд мөрдөгддөг хууль тогтоомж, дүрэм, жуамын сорил / оноо 50/	Ажлын ярилцлага / оноо 30/	Нийт
1	Хүний нөөцийн мэргэжилтэн /ажлын хэсэг/	-	-	-	-
Нийт оноо					-

Ажлын ярилцлага: Гүйцэтгэх ажилтан

№	Нэгжийн удирдлагын ярилцлага	Өөрийгөө илэрхийлэх чадвар /3-10оноо/	Багаар ажиллах чадвар /3-10 оноо/	Компани, ажилын байр сонгосон шалтгаан, нөхцөл /3-10оноо/	Нийт /9-30 оноо/
1	Хүний нөөцийн ажилтан /ажлын хэсэг/				

ҮНЭЛГЭЭ НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН /АЖЛЫН ХЭСЭГ/

...../...../

ОГНОО.....

**СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Сонгон шалгаруулатад хамрагдсан иргэн.

_____ /Эцэг, эхийн нэр/
 _____ /Өөрийн нэр/
 _____ /Регистрийн дугаар/

Ажиллахыг сонирхож буй

Алба, хэлтэс _____

Албан тушаал _____

№	Үнэлгээ өгөх нэгж	Ерөнхий мэдлэгийн сорил /20 оноо	Ажлын байрнд мөрдөгддөг хууль тогтоомж, дүрэм, жуамын сорил / оноо 50/	Ур чадварын оноо / оноо 30/	Нийт
1	Хүний нөөцийн мэргэжилтэн /ажлын хэсэг/	-	-	-	-
Нийт оноо					-

Ур чадвар: Үйлдвэрийн ажилтан

№	Нэгжийн удирдлагын ярилцлага	Нийт /9-30 оноо/	ИТА гарын үсэг
1	Инженер техникийн ажилтны үнэлгээ		

ҮНЭЛГЭЭ НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН /АЖЛЫН ХЭСЭГ/

...../...../

ОГНОО.....